



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАР ХҮРТЭЭМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ЗАРДЛЫН
ҮР АШИГТ ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2020/06/-НА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Ж.Өсөхбаяр
Утас: 99890393 цахим хуудас: usukhbayari@audit.gov.mn
Аудитор П.Амаржаргал
Утас: 88106996 цахим хуудас: amarjargalp@audit.gov.mn



АГУУЛГА

БҮЛЭГ 1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээнд иргэдийг бүрэн хамруулсан уу?	5
1.1. Баянхонгор аймгийн ЗДТГ болон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдвал зохих ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн судалгаа байхгүй байна.....	5
1.2. Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэхдээ сургалт, аян, нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээ зохион байгуулахаас гадна орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчин зэргийг ашиглан хүргэж байна.	5
1.3. 2016-2019 онд нийт хамрагдвал зохих ахмад настны 15.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12.4 хувь нь Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан байна.	6
БҮЛЭГ 2. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөж, үр дүнтэй зарцуулсан уу?	9
2.1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээний зардлыг нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.....	9
2.2. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг зарцуулахдаа холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.	10
БҮЛЭГ 3. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх?	13
3.1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн хяналт хангалтгүй байна.....	13
3.2. Нийгмийн халамжийн сангаас зарим ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, үйлчилгээг олгохдоо холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байгаа нь дотоод хяналтын үр дүн гараагүй байна.....	15
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	17
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:	20
ДҮГНЭЛТ:	21
ЗӨВЛӨМЖ:	22



УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу гүйцэтгэв.

Аудитын зорилт

Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашигт аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

Аудитын хамарсан хүрээ

- Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээнд иргэдийг бүрэн хамруулсан эсэх;

- Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөж, үр дүнтэй зарцуулсан эсэх;

Аудитын хязгаарлалт

- Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх; Аудитаар Баянхонгор аймгийн хэмжээнд Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 2016-2019 онд үзүүлсэн протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, үйлчилгээг түүвэрт хамруулан шалгав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, үйлчилгээнээс бусад нийгмийн халамжийн үйлчилгээг хамааруулаагүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын стандарт-Төрийн аудит MNS6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан аймгийн Халамжийн сангийн дансны хуулганы дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн тайлан мэдээ бусад баримт материалд дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль
- Монгол Улсын 2016-2019 оны Төсвийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”,



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”

- Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”;
- Засгийн газрын 2012 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнэ”
- Засгийн газрын 2017 оны 316 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Ж.Өсөхбаяр, П.Амаржаргал нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2020 оны 07 дугаар сарын 03-ний өдөр аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс, Ахмадын хороонд тус тус хүргүүлэв.



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ 1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээнд иргэдийг бүрэн хамруулсан уу?

Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн нэгдсэн судалгаагүй байгаа бөгөөд Статистикийн дүнтэй харьцуулахад ахмад настны 15.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12.4 хувь нь хамрагдаж 1126.2 сая төгрөг зарцуулжээ.

1.1. Баянхонгор аймгийн ЗДТГ болон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдвал зохих ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн судалгаа байхгүй байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс нь Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн нэгдсэн тоон судалгааг гаргаагүй, энэ талаар мэдээллийн нэгдсэн сан байхгүй, бүртгэлтэй ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлоогүй байгаа нь Ахмад настны тухай хуулийн 7.2.10¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн тоо, судалгааг аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос сар бүр авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэхгүй байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж хөнгөлөлт тусламж үзүүлэх журам”-ын 1.3² дахь заалтыг хэрэгжүүлээгүй байгаа тул аудитад нийт хамрагдвал зохих ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, судалгааг аймгийн Статистикийн хэлтсээс авч аудитын суурь шалгуур болгосон болно.

Иймд цаашид нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдвал, зохих хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн судалгааг аймгийн ЗДТГ-т хүргүүлж Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж хөнгөлөлт тусламж үзүүлэх журам”-ын 1.3³ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст хүргүүлэв.

1.2. Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэхдээ сургалт, аян, нээлттэй өдөрлөг зэрэг арга хэмжээ зохион байгуулахаас гадна орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчин зэргийг ашиглан хүргэж байна.

Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт үйлчилгээ хүргэх мэдээллийг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь өөрийн

¹ аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх.

² Энэхүү журмын 1.2-т заасан комисс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрийн жагсаалтыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газарт сар бүр хүргүүлнэ.

³ Энэхүү журмын 1.2-т заасан комисс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэрийн жагсаалтыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газарт сар бүр хүргүүлнэ.



цахим хуудсаар болон нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах, телевизийн зар зэрэг мэдээллийн сувгуудаар иргэдэд мэдээллийг хүргэж байна. Тухайлбал:

ХХҮГ-ын 2016, 2017, 2018, 2019 онуудын үйл ажиллагааны тайлангаас:

➤ Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг сурталчлан сургалт зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2016 онд 730, 2017 онд 1196, 2018 онд 1150, 2019 онд 1950 гаруй ахмад настанд 1-8 удаагийн давтамжтайгаар мэдээлэл хүргэсэн.

➤ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдөр 2016 онд 510, 2017 онд 1008, 2018 онд 1323, 2019 онд 328 иргэдэд 1-5 удаагийн давтамжтайгаар мэдээлэл зөвлөгөө өгч уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

➤ Аудитад хамрагдсан онуудад Орон нутгийн Баянхонгор телевиз, Хонгор телевизтэй гэрээ байгуулан иргэдэд нийгмийн халамж, хөнгөлөлт үйлчилгээний мэдээллийг хүргэж ажилласан.

➤ Өөрийн www.bayankhongor.hudulmur-halamj.gov.mn цахим хуудас, halamj.gov.mn веб site facebook цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

Иргэдэд халамжийн хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэхдээ аймгийн төвд төрийн нэг цэгийн үйлчилгээ, багийн нийгмийн ажилтан, сумдын нийгмийн ажилтнуудаар дамжуулан баримт материалыг хүлээн авч хянан, мэдээллийн санд шивэлтийг хийж байгаа бөгөөд шивэлт хийгдсэн иргэдийн хөнгөлөлт үйлчилгээний олголтыг тухай бүрд нь олгож байна.

1.3. 2016-2019 онд нийт хамрагдвал зохих ахмад настны 15.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12.4 хувь нь Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан байна.

Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсээс хүн амын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг гаргуулан авсан ба аудитад хамрагдсан 2016-2019 онуудад нийт бүртгэлтэй 28282 ахмад настнуудын 4476 буюу 15.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 14220 иргэний 1762 буюу 12.4 хувийг нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамруулсан байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээнд нийт 2030 иргэн хамрагдаж 2016 оны түвшнээс 1110 иргэнээр буюу 45.3 хувиар нэмэгджээ.

Аудитад хамрагдсан онуудад нийт протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд нийт 1126.2 сая төгрөг зарцуулснаас 72.5 хувь нь ахмад настан, 27.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт үйлчилгээнд олгосон байна.

Хүснэгт 1. Нийгмийн халамжид хамрагдалтын судалгаа /үйлчилгээний төрлөөр/


сая.төг

Төрөл	Ахмад настан								Хөгжлийн бэрхшээлтэй иргэн							
	2016		2017		2018		2019		2016		2017		2018		2019	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
протез	604	118.0	843	129.8	778	138.8	813	173.9	197	41.0	278	46.0	208	39.5	223	45.5
ортопед	41	22.7	72	33.7	105	26.0	619	39.2	26	12.5	238	28.3	53	12.2	116	17.6
тусгай хэрэгсэл	55	4.6	671	38.2	312	22.9	913	69.1	44	5.6	235	23.6	107	13.9	171	23.6
НИЙТ	700	145.3	1586	201.8	1195	187.6	2345	282.3	267	59.1	751	97.9	368	65.6	510	86.6



Аймгийн хэмжээнд нийт хамрагдвал зохих ахмад настнуудын 2016 онд 10.6 хувь, 2017 онд 18.7 хувь, 2018 онд 13.7 хувь, 2019 онд 19.8 хувийг тус тус хөнгөлөлт үйлчилгээнд хамруулснаас Богд сум хамгийн өндөр буюу 24.8 хувийг хамруулсан бол бусад сумдын ахмад настнуудын 20-с бага хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан байна.

АХМАД НАСТАН




Хүснэгт 2. Ахмад настны нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдалтын судалгаа

Сумын нэр	Нийт хамрагдвал зохих	Нийт хамрагдсан	Хамрагдалтын хувь	Үүнээс он тус бүрээр харуулбал			
				2016 он	2017 он	2018 он	2019 он
Богд	964	239	24.8%	9.7%	12.2%	9.9%	63.8%
Баянхонгор	11609	2144	18.5%	12.3%	23.0%	15.4%	22.3%
Жинст	564	89	15.8%	9.7%	29.3%	11.1%	13.0%
Баянбулаг	577	91	15.8%	7.2%	18.0%	11.1%	25.0%
Баянцагаан	956	147	15.4%	12.4%	14.7%	13.8%	20.2%
Галуут	1166	177	15.2%	8.1%	16.0%	14.6%	20.7%
Шинэжинст	620	94	15.2%	9.8%	21.4%	17.0%	12.2%
Баянлиг	1110	164	14.8%	8.3%	15.1%	14.2%	20.5%
Эрдэнэцогт	1124	162	14.4%	8.9%	16.1%	13.7%	18.5%
Жаргалант	1146	164	14.3%	10.1%	18.1%	11.6%	16.6%
Баацагаан	967	137	14.2%	13.2%	16.4%	16.7%	10.3%
Заг	679	96	14.1%	13.1%	15.5%	14.0%	13.9%
Баян-Өндөр	685	96	14.0%	5.7%	19.7%	14.2%	15.6%
Баянговь	811	106	13.1%	5.3%	16.3%	14.5%	15.5%
Бөмбөгөр	874	105	12.0%	13.6%	14.2%	10.3%	10.2%
Хүрээмарал	550	62	11.3%	5.6%	20.3%	13.6%	5.9%
Гурванбулаг	675	76	11.3%	3.9%	9.9%	11.4%	18.3%
Өлзийт	1208	134	11.1%	11.9%	7.1%	11.1%	13.9%
Баян-Овоо	781	84	10.8%	5.6%	11.2%	12.1%	13.5%
Бууцагаан	1216	119	9.8%	11.3%	16.1%	5.4%	6.8%
НИЙТ ДҮН	28282	4486	15.9%	10.6%	18.7%	13.7%	19.8%

Аймгийн хэмжээнд нийт хамрагдвал зохих Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2016 онд 7.3 хувь, 2017 онд 16.2 хувь, 2018 онд 10.7 хувь, 2019 онд 14.7 хувийг тус тус хөнгөлөлт үйлчилгээнд хамруулснаас Баянхонгор, Богд сумд хамгийн өндөр буюу 17.0 хувийг хамруулсан бол бусад сумдын ахмад настнуудын 15-с бага хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН





Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдалтын судалгаа

Сумын нэр	Нийт		Хамрагдалтын хувь	Үүнээс он тус бүрээр харуулбал			
	хамрагдвал	хамрагдсан		2016 он	2017 он	2018 он	2019 он
Баянхонгор	5500	962	17.5%	9.2%	21.6%	15.5%	22.0%
Богд	597	103	17.3%	1.9%	12.6%	1.9%	54.4%
Жинст	307	47	15.3%	5.8%	35.9%	12.8%	16.9%
Баянбулаг	257	33	12.8%	6.0%	15.5%	11.4%	22.2%
Жаргалант	464	57	12.3%	6.3%	17.3%	9.5%	16.2%
Заг	266	30	11.3%	7.4%	11.0%	19.0%	8.1%
Галуут	638	70	11.0%	4.8%	12.2%	11.2%	16.5%
Баянцагаан	468	48	10.3%	9.9%	12.6%	9.5%	8.8%
Эрдэнэцогт	730	72	9.9%	8.2%	11.6%	8.4%	11.6%
Шинэжинст	278	24	8.6%	5.7%	15.7%	2.7%	6.2%
Гурванбулаг	355	28	7.9%	5.0%	11.2%	20.0%	5.0%
Хүрээмарал	383	30	7.8%	11.9%	12.6%	5.3%	4.1%
Бууцагаан	464	36	7.8%	9.2%	10.3%	6.8%	4.6%
Баян-Овоо	349	27	7.7%	11.4%	12.4%	5.7%	2.1%
Өлзийт	554	42	7.6%	7.3%	9.9%	8.3%	4.9%
Баянговь	506	36	7.1%	5.4%	13.5%	3.3%	7.9%
Баацагаан	551	37	6.7%	1.4%	9.6%	9.6%	6.5%
Бөмбөгөр	471	31	6.6%	5.9%	13.2%	2.1%	4.5%
Баянлиг	439	21	4.8%	3.5%	3.3%	2.6%	10.1%
Баян-Өндөр	643	28	4.4%	7.0%	5.7%	8.9%	1.0%
НИЙТ ДҮН	14220	1762	12.4%	7.3%	16.2%	10.7%	14.7%

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.7⁴, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.10⁵ дахь заалтуудын дагуу аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулж байсан бол дээрх тогтоолыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор хүчингүй болгож шинэчлэн баталсны дагуу 2018 оноос Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулан жагсаалтыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлж ажилласан байна.

Аудитад хамрагдсан онуудад гэрээ байгуулсан ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын жагсаалтыг тулган шалгахад аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Дэл оюу дөл” ХХК, “Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв”, “Түмэн чанар” ХХК, “Мон-Анир” ХХК гэсэн 4 байгууллагатай 2017 онд гэрээ байгуулсан, ХХҮЕГ нь 2018 онд 60, 2019 онд 69 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулсан тухай жагсаалтыг аймгийн ХХҮГ-т ирүүлсэн байна.

Аймгийн ХХҮГ-аас 2017 онд аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан гэрээнд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, жагсаалтыг тодорхой тусгаж баталдаггүй

⁴ Энэ журмын 1.2-т заасан ортопед болон тусгай хэрэгслийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагуудаас ахмад настан өөрөө сонгож авна.

⁵ Энэ журмын 1.5-д заасан ортопед болон тусгай хэрэгслийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрөө сонгож авна.



байсан бөгөөд харин 2018 оноос хойш ХХҮЕГ-ын ирүүлсэн ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын жагсаалтад тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үзүүлэх үйлчилгээний төрлийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус бүрээр гарган ирүүлсэн нь үйлчилгээний нэр төрөлд заасан протез, ортопед тусгай хэрэгслийн үйлчилгээг иргэд нээлттэй өөрийн хэрэгцээнд тулгуурлан сонголт хийн авах боломжийг бүрдүүлсэн байна.

бүлэг 2. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг бодитой төлөвлөж, үр дүнтэй зарцуулсан уу?

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагыг бүрэн тооцож төлөвлөөгүй, хууль, журмын шаардлагыг бүрэн мөрдөж зарцуулаагүй байна.

2.1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээний зардлыг нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээний зардлыг төлөвлөхдөө өмнөх оны зардлын гүйцэтгэлийн дүнтэй уялдуулан төлөвлөж байгаа ба нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа, мэдээллийн санг үүсгэж түүнд үндэслэн тооцоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2⁶ дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитад хамрагдсан онуудын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг төсвийн төсөлтэй харьцуулахад 3002 иргэнд 90.7 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлтийн зардал гүйцэтгэлээр илүү байгаа нь зардлын төсвийн төслийг боловсруулахдаа нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 4. Протез, ортопед болон тусгай хэрэгслийн төсвийн төсөл, гүйцэтгэл

Төрөл	Төсвийн төсөл								Гүйцэтгэлээр								Зөрүү							
	2016		2017		2018		2019		2016		2017		2018		2019		2016		2017		2018		2019	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахмад настан	552	91.2	-	111.0	769	235.7	958	235.8	672	145.3	1307	201.8	1001	187.6	1506	282.3	-120	(54.1)	-1307	(90.8)	-232	48.0	-548	(46.5)
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	355	102.5	-	99.3	306	80.0	306	80.0	248	59.1	636	97.9	354	65.6	524	86.6	107	43.4	-636	1.4	-48	14.5	-218	(6.6)
Дүн	907	193.7	-	210.2	1075	315.7	1264	315.8	920	204.4	1943	299.7	1355	253.2	2030	368.9	-13	-10.7	-1943	-89.4	-280	62.5	-766	-53.1

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, тусламжийн зардлыг 2016-2018 онуудад аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байсан бол Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж улсын төсвөөс санхүүжилтийг олгосон байна.

Халамжийн сангийн төсвийн төслийг зардлын нэр төрлөөр боловсруулж байгаа ч аймгийн ИТХ-ын тогтоолоор батлахдаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй

⁶ ... дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх.



иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг нэгтгэн баталж нэг дансаар санхүүжилтийг олгон зарцуулж байгаа тул ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж, хөнгөлөлтийг зардлын төлөвлөгөө, олгосон санхүүжилтийг салгаж харах боломжгүй байна.

Иймд Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8.1⁷-д заасан нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд дүн шинжилгээ хийж түүнд үндэслэн төсвийн төслийг боловсруулж, зардлын нэр төрөл тус бүрээр батлуулж байх зөвлөмжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэв.

Хүснэгт 5. Халамжийн сангийн төлөвлөгөө гүйцэтгэл.

Зардлын төрөл	Батлагдсан төлөвлөгөө				Гүйцэтгэл				Үүнээс: протез, ортопед			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Ахмад настанд нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлт, тусламж	325.7	399.8	399.8	708.4	355.4	538.0	448.8	708.3	145.3	201.8	187.6	282.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлт, тусламж	213.0	124.7	151.1	223.8	171.9	245.1	222.8	227.7	59.1	97.9	65.6	86.6

2.2. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлыг зарцуулахдаа холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Аудитад хамрагдсан онуудад аймгийн хэмжээнд нийт 3781 ахмад настанд 817.0 сая төгрөгийн 5826 төрлийн, хөгжлийн бэрхшээлтэй 1314 иргэнд 309.2 сая төгрөгийн 1896 төрлийн протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж,

ТӨРӨЛ	Нийт олголт		Түүвэрт хамруулсан	
	Үйлчилгээний тоо	Дүн	Үйлчилгээний тоо	Дүн
Ахмад настан	5826	817.0	1170	271.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1896	309.2	573	106.5
НИЙТ	7722	1126.2	1743	378.0

хөнгөлөлтийг олгосон байна. Аудитаар 535 ахмад настны 271.5 сая төгрөгийн 1170 төрлийн хөнгөлөлт, үйлчилгээ, 152

хөгжлийн бэрхшээлтэй иргэний 106.5 сая төгрөгийн 573 төрлийн хөнгөлөлт үйлчилгээг түүвэрт хамруулан шалгалаа.

Аудитын илрүүлэлт:

Аудитын түүвэрт хамрагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж, хөнгөлөлтөөс Баянхонгор, Бууцагаан сумдын 3 иргэний 0.4 сая төгрөгийн 4 төрлийн хөнгөлөлт, үйлчилгээний анхан шатны баримтыг аудитын хугацаанд баримт олдоогүй гэх шалтгаанаар шалгуулаагүй болно.

Хүснэгт 6. Ахмад настны протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж, хөнгөлөлт /баримт олдоогүй/

№	Шифр	Үйлчилгээний нэр	Олгосон огноо	Олгосон	Сум	Он	Харицсан албан тушаалтны	
							Овог нэр	Албан тушаал
1	5130	Хөтөвч, суултуур (насанд хүрэгсэд)	2019-02-27	80,000	Баянхонгор	2019	Д.Сангидулам	Мэргэжилтэн
2	5149	Нурууны ширэн хамгаалалт	2019-09-25	150,000	Баянхонгор	2019	Д.Сангидулам	Мэргэжилтэн
3	5134	Контактны линк (+5, -5 болон түүнээс дээш)	2018-04-23	87,000	Баянхонгор	2018	Д.Сангидулам	Мэргэжилтэн
4	5113	Шүд	2016-02-22	120,000	Бууцагаан	2016	Н.Соджамц	Мэргэжилтэн
НИЙТ				437,000				

⁷ тухайн сум, хорооны нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;



Иймд дээрх 3 иргэнд олгосон 0.4 сая төгрөгийн 4 төрлийн хөнгөлөлт үйлчилгээний анхан шатны баримтыг байгууллагын архивт авч хадгалах баримтыг өгөөгүй тохиолдолд Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь заалтын дагуу холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх хугацаатай албан шаардлагыг аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 3.1⁸, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ын 6.1⁹-д заасан баримт бичгийг бүрдүүлээгүй, эсхүл тухайн иргэнд ортопед болон тусгай хэрэгсэл

шаардлагатай эсэхийг бүрэн тодорхойлоогүй байхад нийгмийн халамжийн сангаас тусламж хөнгөлөлт үзүүлсэн зөрчил илэрлээ.	Өргөдөл	14	0.6
	Иргэний үнэмлэхийн хуулбар	1	5.0
	Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр	1	0.5
	ЭМТ-ийн эмчийн тодорхойлолт	115	74.7
	Нийгмийн даатгалын тодорхойлолт	6	31.0

Аудитын илрүүлэлт:

Аудитад хамрагдсан хугацаанд 110 ахмад настан журамд заасан баримтыг бүрдүүлээгүй, эсхүл бүрдүүлсэн баримт нь тухайн иргэнд ортопед болон тусгай хэрэгсэл шаардлагатай эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй байхад 128.9 сая төгрөгийн 137 төрлийн хөнгөлөлт олгосон байна.

Иймд Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ыг хэрэгжүүлж дутуу бүрдүүлсэн болон шаардлага хангахгүй баримт материалаар протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж, хөнгөлөлтийг олгодог явдлыг зогсоож зөрчлийг арилган цаашид гаргахгүй байх зөвлөмжийг аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

Мөн сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмч нар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тодорхойлолтыг гаргахдаа тус иргэнд тухайн ортопед болон тусгай хэрэгсэл шаардлагатай эсэхийг бүрэн тодорхойлж гаргахгүй байгаа тул нийгмийн халамжийн хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах иргэдийн тодорхойлолтыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ын 6.1.3¹⁰ заалтад нийцүүлэн гаргахад нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэв.

Аудитад хамрагдсан онуудад хуульд заасан насанд хүрээгүй, нас барсан иргэдэд хөнгөлөлт тусламж олгосон зэргээр нийт 7 иргэнд сангаас 1.0 сая төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1¹¹-д заасан насанд хүрээгүй Хүрээмарал сумын шилбэний протез, хиймэл шүд хийлгэсэн 2 иргэнд 520.0 мянга, Бууцагаан сумын хиймэл шүд хийлгэсэн 2 иргэнд 240.0 мянга нийт 760.0 мянган төгрөг олгосон.
- Баацагаан, Бууцагаан, Баянхонгор сумын тус бүр нэг иргэнд нас барснаас хойш нийт 220.0 мянган төгрөгийн хиймэл шүд, тусгай хэрэгслийн үнийг сангаас олгосон.

⁸ Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-д заасан хөнгөлөлт авах хүсэлт гаргахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

⁹ Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д заасан дэмжлэг авах хүсэлт гаргахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

¹⁰ ... ортопедийн болон тусгай хэрэгсэл шаардлагатай болохыг тодорхойлсон аймаг, нийслэлд эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн бичиг, сум, тосгонд эрүүл мэндийн төвийн ерөнхий эмчийн тодорхойлолт

¹¹ Энэ хуулийн үйлчлэлд 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн хамаарна.



• Нүдний уян болор хийлгэсэн Баянхонгор сумын нэг иргэнд 405.0 мянган төгрөг дутуу олгосныг 2020 оны 04 дүгээр сард хийсэн дотоод хяналт шалгалтаар илрүүлж төлбөрийг барагдуулахаар шийдвэрлэсэн байна.

Иймд дээрх 8 иргэнд сангаас илүү олгосон 980.0 мянган төгрөгийн зөрчлийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5¹² дахь заалтын дагуу холбогдох буруутай албан тушаалтнуудаар орон нутгийн төсөвт төлүүлэхээр **төлбөрийн акт** тогтоов.

Аудитад хамрагдсан онуудад аймгийн ХХҮГ болон ХХҮЕГ-тай ортопед болон тусгай хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулаагүй 24 аж ахуйн нэгжээс 4.3 сая төгрөгийн 42 төрлийн тусгай хэрэгсэл худалдан авсан 38 иргэнд сангаас тусламж, хөнгөлөлт олгосон нь Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 1.7¹³ дахь заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ын 2.5¹⁴ дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 7. Гэрээгүй аж ахуйн нэгжээс хөнгөлөлт үйлчилгээ олгосон жагсаалт /аж ахуйн нэгжээр/

Байгууллага ААН-ийн нэр	2016		2017		2018		2019		Байгууллага ААН-ийн нэр	2016		2017		2018		2019		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Алсын оч оптик ХХК							1	15,000	Наянбулаг ганга ХХК								3	45,000
Алтан хөхийн оргил ХХК					2	60,000			Отгон буянт хүрээ ХХК	1	50,000							
Баян цэцүүхэй			1	20,000					Рехтус ХХК	1	80,000							
Глауком ХХК	1	15,000							Сити оптик					1	100,000			
Долоон отго	2	100,000	1	30,000	1	80,000	4	190,000	Сод совин ХХК	1	33,000							
Дэл Оюу Дэл ХХК-ний “Эрхэм чанар” протезийн үйлдвэр	2	450,000							Талим оптикал					1	100,000			
Мон-Анир	1	350,000							УБААОД ХХК зүүм оптикал					1	100,000			
Монос Мойл	1	25,500							Фармед ресурс	1	35,000							
Монос фарм трейд	1	30,000							ХБИНТөв			5	610,000					
Монос эм ханган	1	40,000							Хонгор хайрханы сүлд ХХК					1	50,000			
Монос энжин					2	130,000			Хос талим					1	100,000			
Мөнхийн тун мед ХХК			1	40,000					ЭМЖОК ХХК			3	1,400,000					
									НИЙТ ДҮН	13	1,208,500	11	2,100,000	10	720,000	8	250,000	

Иймд гэрээгүй байгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас ортопед болон тусгай хэрэгсэл худалдан авсан иргэдэд сангаас тусламж, хөнгөлөлт олгосон холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг аймгийн ХХҮГ-т хүргүүлэв.

Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн жишиг үнийг Засгийн газрын 2012 оны 153 дугаар тогтоолоор тогтоож, 2017 оны 316 дугаар тогтоолоор шинэчилсэн ба аудитад хамрагдсан онуудад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт олгохдоо тус жишиг үнийг мөрдөж ажилласан байна.

Аудитын түүвэрт хамрагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах протез, ортопед болон тусгай хэрэгслийг нийт 54 аж ахуйн нэгж байгууллага иргэдэд нийлүүлсэн байна.


¹² Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

¹³ Энэ журмын 1.2-т заасан ортопед болон тусгай хэрэгслийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан байгууллагатай гэрээ байгуулсан байгууллагуудаас ахмад настан өөрөө сонгож авна.

¹⁴ Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чанарын шаардлага хангасан протез хийх, ортопедийн болон тусгай хэрэгслээр хангах үйлчилгээ үзүүлэх байгууллагын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл (хаяг, байршил, утасны дугаар)-ийг гаргаж аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ.



Дээрх аж ахуйн нэгжүүд ихэнх нь алхуулагч, хөтөвч суултуур, тохойн тулгууртай таяг, тохойвчтой суга таягийг нийлүүлсэн, эдгээр бэлтгэн нийлүүлэгчийн үнийг Засгийн газрын тогтоолоор баталсан жишиг үнэтэй харьцуулахад алхуулагч 70.0 мянга, хөтөвч суултуур 170.0 мянга, тохойн тулгууртай таяг 15.0 мянга, төмөр суга таяг 10.0 мянга хүртэл төгрөгийн илүү үнээр нийлүүлж байгаа ч сангаас хөнгөлөлтийг олгохдоо жишиг үнийн дагуу олгож зөрүүг иргэн өөрөө төлж байна.



БҮЛЭГ 3. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн болон дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн хяналт хангалтгүй, дотоод хяналт шалгалтын үр дүн гараагүй байна.

3.1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд тавих хөндлөнгийн хяналт хангалтгүй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээнд аудитад хамрагдсан 2016-2019 онуудад Мэргэжлийн хяналтын байгууллага 2017 он, 2018 оны эхний хагас жилд хяналт хийж бусад



онуудад хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 24.7¹⁵ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд 2017 он, 2018 оны эхний хагас жилд урьдчилан сэргийлэх шалгалтыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/168 дугаар бүхий удирдамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар хийжээ.

Шалгалтаар “Дуут Баян Богд” ХХК-аас ирүүлсэн санхүүгийн баримттай хувийн хэргийг тулган шалгахад 412,5 мянган төгрөгийн үйлчилгээг нэр бүхий 4 иргэнд үзүүлэхдээ эмчийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдсэн, гэрээний дагуу үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудаас ирүүлж буй хувийн хэрэг болон санхүүгийн баримтын үнэн зөв, бүрэн гүйцэт, стандартын шаардлага хангасан эсэхийг тухай бүр нягтлан шалгаж хүлээн авсны дараа төлбөр тооцоог гүйцэтгэж хэвшээгүй гэсэн зөрчил илэрснийг арилгах давтан гаргахгүй байх санал хүргүүлж ажилласан ба харин 2016, 2019 онуудад хяналт шалгалт хийгээгүй байна.

Иймд Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон хөнгөлөлт, үйлчилгээнд хяналтыг жил бүр хийж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэв.

Ахмадын байгууллагаас 2016-2019 оны хооронд нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ын 7.1¹⁶ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд ахмад настанд нийгмийн халамжийн сангаас олгосон үйлчилгээний чанарт хяналтыг жил бүр тогтмол хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ахмадын байгууллагад хүргүүлэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/196 тоот тушаалаар батлагдсан удирдамжаар “Хяналт, мониторингийн” газраас хяналт шалгалтыг 2019 оны 11 дүгээр сард ХХҮГ-ын дотоод үйл ажиллагаа, төсвийн болон халамжийн сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын үйл ажиллагааны 2018 оны санхүү, аж ахуйн тайлан мэдээ баримт, бусад холбогдох материалын хамруулан хяналт шалгалт хийгдсэн байна.

¹⁵ Нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

¹⁶ Дэмжлэг, тусламж, хөнгөлөлт олгох үйл ажиллагаа, ахмад настанд үзүүлэх үйлчилгээний чанарт... ахмадын байгууллага тус тус хяналт тавина.



Уг шалгалтаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, үйлчилгээний зардлын олголт хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт шалгалттай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна. Харин бусад онуудын сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийгдээгүй байна.

1 Сангийн үйл ажиллагаанд хийгдсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт, үйлчилгээний зардлын олголттой холбоотой зөвлөмж өгөгдөөгүй бөгөөд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 он 2018 оны эхний хагас жилийг хамруулан хийсэн хяналт шалгалтаар 2 төрлийн зөрчил илэрснийг арилгах санал зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлтийг хэрхэн тооцсон талаар нотлох баримтыг аудитын хугацаанд гаргаж өгөөгүй болно.

3.2. Нийгмийн халамжийн сангаас зарим ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, үйлчилгээг олгохдоо холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байгаа нь дотоод хяналтын үр дүн гараагүй байна.

Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардлын олголт болон санхүүгийн баримтад дотоод хяналтыг 2018, 2020 онуудад хийж ажилласан байна. Гэвч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал он тус бүрд дахин давтагдан гарч байгаа нь дотоод хяналт шалгалтын үр дүн гараагүй байгаа бөгөөд хяналтаар өгсөн зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд хэрэгжүүлэн ажиллахгүй байгаагаас зөрчил дутагдал арилахгүй давтан гарсаар байна.

Дотоод хяналт шалгалт хийгдсэн 2017, 2018 онуудад халамжийн сангаас олгож буй хөнгөлөлт үйлчилгээнд дараах зөрчил дутагдал гарсан байна.

Баянхонгор аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хяналтын хэлтсийн 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн №08 тоот удирдамжаар 2017 онд, 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн №02 тоот удирдамжаар 2019 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, ахмад настанд олгосон” хөнгөлөлтийн олголт, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгдсэн бөгөөд шалгалтаар баримтын бүрдэл дутуу, wais программд ахмад настныг хөгжлийн бэрхшээлтэй иргэний шифрээр шивсэн, сонсголын аппаратыг баруун зүүн чихээр тус тусад нь шифрээр шивэх байсныг нэг шифрээр шивсэн, шүдний хөнгөлөлт авах эрх үүсээгүй иргэнд хиймэл шид хийлгэсэн хөнгөлөлт олгосон, протез, ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг олгохдоо шифр буруу шивснээс шалтгаалан үнийг илүү, дутуу олгодог, зарим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлэх эрхгүй



байгууллагаас авсан тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг олгосон зэрэг зөрчлүүд илэрсэн ба энэ зөрчил аудитаар давтагдан гарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, ахмад настанд олгосон хөнгөлөлтийн олголт, санхүүгийн баримтад хяналт шалгалтыг тухай бүр хийдэг байсан бөгөөд ХХҮГ-ын удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2017 оны 6 дугаар 02-ны өдрөөс эхлэн жилийн ажлын төлөвлөгөөнд оруулан удирдамжаар хяналт шалгалт хийдэг болсон ба хяналт шалгалт тухай бүр хийгдэхгүй байгаатай холбоотой баримтын бүрдэл дутуу, wais программд ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шифрийг хооронд нь зөрүүлэн буруу шивэх, хос эрхтний шифрийг салгаж шивэхгүй байх зэрэг алдаа давтан гарсаар байгаа нь хяналтыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тухай бүр хийж байхаар шийдвэрлэсэн байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар 2018 онд 18, 2020 онд 15 зөвлөмжийг холбогдох хэлтэс тасаг болон албан тушаалтнуудад хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа хэдий ч хангалтгүй алдаа зөрчил давтан гарсан байна.

Аудитаар нийт 134.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.0 сая төлбөрийн акт тогтоон, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 0.4 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас 4.3 сая төгрөгийн ортопед болон тусгай хэрэгсэл худалдан авсан иргэдэд сангаас тусламж, хөнгөлөлт олгосон холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлт авах эрх үүссэн 137 иргэн Нийгмийн даатгалын тодорхойлолт, өргөдөл, эмнэлэгийн тодорхойлолт гэх мэт анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байхад сангаас 129.0 сая төгрөг олгосон зөрчлийг цаашид давтан гаргуулахгүй байх зэрэг нийт 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн ажиллав.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашигт хийсэн нийцлийн аудитын тайлантай холбоотой аймгийн ХХҮГ-ын даргын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 580 тоот албан бичгээр дараах 6 саналыг ирүүлсэн байна



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-00-10, 70-44-00-30

2020.07.02 № 580

танай _____ -ны № _____ -т

Г Санал хүргүүлэх тухай Г

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

M. Oorjigyn
Амалын гүйцэтгэл үзэх.
2020.07.02

Тус газар нь “Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Ахмад настны тухай хуулийн 7.2.10. “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум хорооны нийгмийн ажилтан нь ахмад настны нөхцөл байдлыг судлан, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, тэдгээрээс сонголт хийхэд туслах, зөвлөгөө өгөх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж Ортопед болон тусгай хэрэгслийн хэрэгцээний судалгааг 2018, 2019 оноор гарган ажиллаж байгаа бөгөөд холбогдох судалгааг шалгалтын явцад танай байгууллагын шалгалтын бүрэлдэхүүнд хүргүүлсэн бөгөөд хамрагдвал зохих иргэдийн нэгдсэн судалгаагүй гэсэн саналтай нийцэхгүй байна. Учир нь жил болгон сумдаас хэрэгцээний судалгаа гаргуулан тухайн судалгаан дээр үндэслэн төсвийн төсөлд саналаа явуулдаг боловч төсвийг батлахдаа бидний явуулсан саналаар төсөв батлагдаж ирдэггүй, тусгай хэрэгсэл шаардлагатай иргэдийн хэрэгцээг тухайн жилд нь 100 хувь хангах боломжгүй байдаг ба хэнд ямар тусгай хэрэгсэл хэрэгтэй болохыг урьдчилан тооцоолох боломжгүй байдаг зэргээс шалтгаалан хэрэгцээний судалгааг гаргах боломжгүй болно.
2. Тусгай хэрэгсэл авахаар хүсэлт гаргасан Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болгонд олгох боломжгүй Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод



хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа, шүд /үнэт металлаар хийхээс бусад/-ний протезийн дотоодод хийлгэсэн зардлын үнийг гурван жилд нэг удаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох, 26.1.3 үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезын үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох, 26.1.4 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох гэсэн заалтуудыг тус тус үндэслэн тухайн онд батлагдсан төсөвт багтаан иргэдэд үйлчилгээг хуулийн дагуу **хугацаан дээр** нь анхаарч үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

3. Энэбиш овогтой Баасандорж /ВЙ56021013/ нь 1956 оны 02 дугаар сарын 10-ны өдөр төрсөн бөгөөд 2016 оны 02 дугаар сарын 10 ны өдөр 60 нас хүрсэн бөгөөд иргэн Э.Баасандоржийн шүдний мөнгийг олголт хийхдээ 2016 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хийсэн нь 60 нас хүрэхэд 4 хоног дутуу байхад гүйлгээ хийгдсэнийг хуульд заасан насанд хүрээгүй байхад олгосон байна гэж үзэн акт тавьсан байна. Учир нь Нийгмийн халамжийн сангийн санхүүжилтийг сар бүрийн 10-15 хооронд иргэдэд олгодог бөгөөд 2016 оны хаврын тэргүүн сарын сар шинийн баяр 2016 оны 02 дугаар сарны 09-ны өдөр болсонтой холбогдуулан тухайн халамжийн сангийн мөнгийг 2016 оны 02 дугаар сарын 06-ны өдөр олголтыг хийсэн нь акт тавих үндэслэл болохгүй гэж үзэж байна. Иймд тухайн сарын онцлогийг харгалзан үзэж иргэн Э.Баасандоржид олгосон шүдний мөнгөний 120.000 төгрөгийг актын төлбөрөөс хасаж өгнө үү.
4. Иргэн Доржготов овогтой Даваадагва /ВЭ53042677/ нь 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдөр нас барсан байхад хиймэл шүд хийлгэсэн 100.000 төгрөгийн олголтын гүйлгээг 2019 оны 01 дүгээр сарын 29-ний



өдөр шилжүүлсэн нь холбогдох мэргэжилтэн нь ажилдаа хайнга хандаж алдаа гаргасан байна. Тухайн иргэний дансны үлдэгдлийг төрийн банкнаас тодруулахад шүдний мөнгөний үлдэгдэл 100.000 төгрөг дансанд нь байна гэсний дагуу манай байгууллага төрийн банк руу албан тоот хүргүүлэн иргэн Д.Даваадагвын шүдний мөнгөний 100.000 төгрөгийг халамжийн сангийн 232100675066 тоот дансанд буцаан төвлөрүүлэн татсан тул танай байгууллагаас тавьсан актын төлбөрөөс хасуулах саналтай байна./ холбогдох материалыг хавсаргав/.

5. Иргэн Барамсай овогтой Нямсүрэн /BM69112502/ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд 2016 оны 03дугаар сарын 22-ны өдөр нийгмийн халамжийн сангаас шүдний мөнгө олгосон бөгөөд тухайн үед ашиглагдаж байсан ХҮМ программаас шалтгаалан ХБИргэний хөнгөлөлт тусламжийг программд шивэлт хийхэд зарим үйлчилгээний шифр алдаатай байснаас шалтгаалан Ахмад настны кодоор шивэлт хийж олголт хийдэг байсантай холбоотойгоор ХБИргэн Б. Нямсүрэнгийн шүдний мөнгө болох 120.000 төгрөгийн актыг хасуулах саналтай байна. /холбогдох 7 хуудас материалыг хавсралтаар/
6. Аудитаар нийт 135,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн гэж тайлангийн төсөлд тусган оруулсныг зөвшөөрөхгүй байна учир нь эрх үүсээгүй хүмүүст 135,2 сая төгрөгийн тусгай хэрэгслийг их хэмжээгээр олгосон мэт харагдахаар байна Иймд: нийт 135,2 сая төгрөгийн зөрчил илэрсэн гэж оруулсан төслийн агуулгыг тайланд тусгуулахдаа гарсан зөрчлийг мөнгөн дүнгээр хэмжихгүй, тухайн иргэдэд тусгай хэрэгсэл олгох эрх нь үүссэн боловч анхан шатны баримт болох өргөдөл, эмнэлгийн тодорхойлолт, НД-ийн тодорхойлолт, багийн засаг даргын тодорхойлолт гэх мэт анхан шатны бичиг баримтын бүрдэл дутуу зөрчил байсан гэж тайланд тусгуулах саналтай байна.

Хавсралт 12 хуудастай.

ДАРГА  Д.АМАРСАНАА





САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

№	Санал	Саналд өгсөн тайлбар
1	САНАЛ-1	Аудитын хугацаанд ирүүлсэн хэрэгцээний судалгаа нь аймгийн хэмжээний ахмад настны тоо, судалгаа, түүнээс хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдсан болон хамрагдаагүй иргэдийн нэгдсэн суурь судалгаа гарган түүнд үндэслэн тооцсоныг нотлох боломжгүй дээрх судалгаа байхгүй байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
2	САНАЛ-2	Тус саналтай холбоотой тайланд зөрчил тусгагдаагүй байгаа тул саналыг хүлээж авах боломжгүй.
3	САНАЛ-3	Тус саналд тусгагдсан иргэн нь Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан насанд хүрээгүй байхад олголт хийгдсэн тул саналыг хүлээж авах боломжгүй.
4	САНАЛ-4	Тус зөрчил нь аудитаар илэрч мөнгийг санд буцаан татаж зөрчилд тооцогдох тул актын дүнгээс хасах саналыг хүлээн авах боломжгүй.
5	САНАЛ-5	Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон актыг ирүүлсэн нь тухайн иргэн нь сангаас хөнгөлөлт тусламж авах эрх үүссэн байгаа тул саналыг хүлээн авч актын дүнгээс хасав.
6	САНАЛ-6	Тус байгууллагын ирүүлсэн саналын дагуу зөрчлийн нэмэлт мэдээллийг тодруулж оруулсан бөгөөд зөрчил нь үнийн дүнгээр илэрхийлэгдэж байгаа тул гарсан зөрчлийг мөнгөн дүнгээр хэмжихгүй гэсэн саналыг хүлээж авах боломжгүй.



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. 2016-2019 онд нийт хамрагдвал зохих ахмад настны 15.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12.4 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдаж 1126,2 сая төгрөгийг зарцуулсан байна.
2. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн тоо, нэгдсэн судалгаа аваагүйгээс аймгийн ЗДТГ-т нэгдсэн мэдээллийн сан байхгүй байна.
3. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн хөнгөлөлт үйлчилгээний зардлыг нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөөгүй байна.
4. Нийгмийн халамжийн сангаас зарим ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээ олгохдоо холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
5. Нийгмийн халамжийн сангаас зарим ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох хөнгөлөлт, үйлчилгээний зардалд холбогдох хууль, журмыг зөрчсөн байгаа нь хөндлөнгийн болон дотоод хяналт хангалтгүй, хяналтын үр нөлөө гараагүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРСАНАА ТАНАА:

1. Аймгийн хэмжээний ахмад настны хөнгөлөлт үйлчилгээ авах иргэдийн тоо, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж мэдээллийн сан үүсгэж мэдээллээр тогтмол хангаж ажиллах.
2. Нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаанд дүн шинжилгээ хийж түүнд үндэслэн төсвийн төслийг боловсруулж, төсвийг зардлын нэр төрөл тус бүрээр батлуулж байх.
3. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ыг хэрэгжүүлж дутуу бүрдүүлсэн болон шаардлага хангахгүй баримт материалаар протез, ортопед болон тусгай хэрэгслийн тусламж, хөнгөлөлтийг олгодог явдлыг зогсоож зөрчлийг давтан гаргахгүй байх.
4. Гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас ортопед болон тусгай хэрэгсэл худалдан авсан иргэдэд сангаас тусламж, хөнгөлөлт олгосон холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг давтан гаргуулахгүй байх.
5. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон хөнгөлөлт, үйлчилгээний хяналтыг тухай бүр хэрэгжүүлж хяналт шалгалтын үр дүнг сайжруулж ажиллах.

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.БАТЦЭЦЭГ ТАНАА:

1. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмч нар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тодорхойлолтыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журам”-ын 6.1.3 заалтад нийцүүлэн гаргахад нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах.

АЙМГИЙН АХМАДЫН ХОРООНЫ ДАРГА Ж.ЭНХБАЯР ТАНАА:

1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настанд олгосон тусламж хөнгөлөлт, үйлчилгээний чанарт хяналт тавьж Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”-ын 7.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

6417143544
84740067 8007423